

Хүлэгү хааны эхний байлдан дагуулал ба Исмаиллийнхан

Д. Баярсайхан\*

Ойрх болон Дундад Дорнодын түүхэнд XIII-р зууны Монголчуудын байлдан дагуулал маш их өөрчлөлтийг авчирсан билээ. Монголчууд тэр хавийнхныг хөгжлийн огт төсөөлөгдөөгүй голдрилд оруулснаар барахгүй найман зууны туршид тэрхүү нутгийг захиран байсан Аббасын Калифын удам угсааг дуусгавар болгосон юм. Үүний хажуугаар ач холбогдлоороо огт дутахгүй нэгэн үйл явдал монголчуудын оролцоотой болж Дундад Дорнодын бас нэгэн хүчтэй удам угсааны түүх тасалдахад хүргэсэн юм.

Хэрэв бид түүхээ сөхөж үзвэл тэртээ 1256 оны эцсээр эзэн Чингис хааны үр сад Иран, Ирак, Афганистан, Кавказ, Бага Ази буюу Анатоли, Дээд Месопотамид Ил хаадын улсыг бий болгожээ.

Эзэн Чингис хааны ач хүү Хүлэгү хаан (1256-65)<sup>1</sup> эл гүрнийг үүсгэн байгуулсан ба Лалын ертөнц дэх Аббасидын Калифыг устгахаар Мөнх хааны (1251-59) зарлигаар Иранд анх илгээгджээ. Хүлэгү бол Тулуй хааны 5 дахь хүү бөгөөд, эх Сорхохтани Беки нь эцгээсээ хойш өнчин үлдсэн хүүхдүүдээ ухаантай, дайчин төлвөөр хүмүүжүүлж Мөнх, Хубилай хөвгүүд нь Их хаадын суудалд заларсан бол хүү Хүлэгү нь Ил хаадын улсыг байгуулсан байна. Хүлэгүгийн авааль эхнэр Тогос хатагч нэр нөлөөтэй Монгол хатдын нэг бөгөөд Нестор Загалмайтан болох Хэрэйд аймгийн үр удам байжээ. Тэр бээр Дундад Дорнодын байлдан дагуулалд оролцож явахдаа Багдадын сүйрлээс олон Загалмайтнуудыг ивээлдээ авч аварсан түүхтэй.

Бидний Монгол өвөг дээдэс дэлхий дахинаа өөрсдийн хүчийг сорих үлс гүрнийг сайтар мэддэг байжээ. Үүний нэг жишээ нь Монголын Нууц Товчоонд тодоор дүрслэгдсэн байдаг. 1221 онд Зүчи, Цагаадай, Өгөөдэй, гурав Хорезмын нийслэл Гүрганжийг (Өрүнгэчи) эзэлж буулгасны дараа эцэгтэйгээ Талиганд (Афганистаны нутаг) нийлэхэд Чингис хаан өөрт нь

\* Монгол Улсын Их Сургууль, *Монгол Судлалын төв*

<sup>1</sup> Хүлэгү хаан 1265 онд 44 настайдаа нас барсан, дэлгэрэнгүйг Rashīd al-Dīn, *Jāmi' al-Tavārīkh*, 1954, 678, Spuler, *History of the Mongols*, 1972, 121-22; Charles Mellville, "Doquz Khatun", *Encyclopedia Iranica*, 1996, 475-76, зэргээс үз.

хувь эс гаргасанд хилэгнэж хөвгүүдтэйгээ гурван хоног уулзалгүй өнгөрөөжээ. Хөвгүүд буруугаа ухаарч айж балмагдахад тэднийг өмгөөлж Боорчи, Мухали, Шихихутуг нар өчил өчиж, “*Сартуул иргэний Султаныг доройтуулж бидний олон эрс, агт морьд чинь бахдаж амуу. Хуваагдаж автах балгас хуваан авсан хөвгүүд бүгд Чингис хааных буй*” хэмээжээ. Чингис хаан тайтгарч гурван хөвгүүдийг

*Өтгөс үгс эшилж,  
Хуучин үгс сануулж,  
Байсан газар  
Багтан алдтал,  
Магнайн холс  
Арчин ядтал*

буруушааж машид зэмлэхэд Хонхай, Хонтагар, Чормахан хорчи нар Чингис хаанд өчрүүн:

*“Бор шувууг анд сургах мэт хөвгүүд сая өдий аялан сурч бүхүйд хөвгүүдийн зүрхийг шантлан энэ мэт яахин ингэж донгодно? Хөвгүүд айж сэтгэлээ алгасуузай. Наран шингэхээс ургах зүг хүртэл дайсан иргэн буй. Маныг төвд ноход мэт турхиран илгээвээс, дайсан иргэнийг дарж, бид тэнгэр газарт хүч нэмэн, алт мөнгө, агуурс таваар, ард иргэдийг чамд авчирсугай. Аль иргэн хэмээвээс, энэ өрнө Багдад иргэний Халибай султан [Caliph al-Nāṣir] гэгч буй хэмээмүү. Түүнд бид аялсугай”*

хэмээн өчвөөс Чингис хаан тайтгаран зөвшөөрч Өтэгэйд аймгийн Чормаханыг Багдад иргэнд аялуулав.<sup>2</sup> Энэхүү хэсгээс үзэхэд Багдадын байлдан дагууллыг тэртээ 1220-иод онд ярилцаж дайлаар мордуулахаар зэхэж байжээ.

Гэвч Хүлэгү хааны байлдан дагуулал 1256 онд Багдадын Калифыг буулгаснаар эхэлсэнгүй. Түүний анхаарал Дундад Дорнодын нэгэн хүчирхэг, нөлөө бүхий улс төрийн хүчний эсрэг чиглэсэн байлаа. Энэ нь Исмаилийнхан хэмээгчид байлаа. Исмаилийнханыг дурдахгүйгээр Ил хаадын түүхийг ярьж бичих хандлага байгаа тул энэхүү сэдвийг онцлон ярих шаардлагатай гэж үзсэн юм.

Низари Исмаилийн түүх судлаач Др. Надя Жамал Монголчуудын байлдан дагууллыг дүгнэхдээ Исмаилийнханы түүхнээ тохиолдсон цорын ганц хийгээд хамгийн хөнөөлт үйл явдал мөн гэжээ. Ийнхүү дүгнэх болсон учир юунд байна вэ гэвэл Монголчууд Исмаилийн хүн амыг хүйс тэмтэрч Исмаилийн сүүлийн Имам буюу шашин-төрийн тэргүүнийг баривчилж хороогоод удам угсааг нь хөнөөсөнд байгаа юм.<sup>3</sup> Энэхүү түүхэн үйл явдал чухамхүү ямар улбаатай болох талаар миний бие сонирхон Исмаилийн Дээд тэргүүн Рукн ал-Дин Хур-Шаг /Rukn al-Dīn Khur-Shāh/ хэрхэн үхсэн тухай судлах болсон юм.

Юуны өмнө Исмаилийнхан гэж хэн байсныг тодруулъя. Лалын ертөнц дотроо хоёр гол урсгалд хуваагддагийг та бүхэн сайтар мэднэ. Энэ нь Сунни (سنة لاه) буюу “үлгэр жишээ хүмүүс” ба Шиа (شيعة) буюу “Алиг дагалдагч”. Шиачууд бол цөөнх нь бөгөөд Сунни

<sup>2</sup> Монголын Нууц Товчоо, 2004, §260.

<sup>3</sup> Jamal, *Surviving the Mongols*, 2002, 3.

Мусалманчуудаасаа шашныхаа үндсэн асуудал дээр зөрчилддөг. Тэр нь Исламын үндсэн номлогч Мухаммадын дараах гурван калифыг алгасаад Мухаммадын охин Fāṭima al-Zahra-тай гэрлэсэн Мухаммадтай цусан холбоотой байсан Алиг өөрсдийн шашны удирдагч хэмээн үздэгт оршино. Шиа дотроо бас хэдэн бүлэгт хуваагддаг, тэдний голлох нэг бүлэг бол Исмаилийнхан юм. (721-755 онд амьдарч байсан Имам Ismā'īl ibn Jaf'ar al-Ṣādiq-ыг хүлээн зөвшөөрснөөр тэд ийнхүү нэрлэгдэх болсон юм). Исмаилийнхан 11-р зуунд гадаад ертөнцөд *хашишин* буюу *ассассин* (захиалгаар аллага хийгч) гэсэн нэрээр алдартай болсон. Тэд үндсэн Сунни үзэлтнүүд хийгээд бусадтай үргэлжийн сөргөлдөж байсан учир олон хүний амь гарздалгүй дайсныхаа толгойлогчийг хороодгоороо алдартай болжээ. Исмаилийн тэргүүн бидний мэдэх “уулын өвгөн” Хасан Саббах (1034-1124) 11-р зууны сүүлээр Иран дахь Эльбрус уулнаа шашиндаа хүмүүс элсүүлж нутагшуулснаар *хашишин* нэр тархсан гэж үздэг. Хасан Саббах залуусыг диваажингийн амьдралтай болгоно гэсэн амлалтаар *хашиши* буюу мансууруулах бодис өгч уулнаа шилжүүлэн бүгүүлж байжээ. Тэрхүү нутагшсан уулын нэг нь 2,100 м өндөр Аламут буюу “Бүргэдийн Үүр” юм. Ассассин нэр нь *хашишинийн* гэсэн нэрээс гаралтай гэж голдуу дүгнэдэг бол миний бие 2004 онд Аламут уулнаа гарч байхад *Хасан Саббахын* нэрээс гаралтай гэж нутгийн нэг ард бас тайлбарлаж байсан. Аль ч хувилбар нь байлаа, ассассин нэр хүмүүний түүхнээ үлдэж өнөөгийн амьдралд ч үндсэн утга санаагаа алдаагүй байна.

Тэр үеийн монголчууд Исмаилийнханий тухай хэр мэдлэгтэй байсан юм бэ?

Үүнийг олж мэдэхийн тулд сурвалж бичгүүдийг судлах хэрэгтэй. Гэтэл эрдэмтэн мэргэд Исмаилийн тэр үеийн түүх тэр чигээрээ монголчуудын гарт үрэгдсэн гэж үздэг. Тийм юм уу гэхэд бас тийм биш байдаг. Ном сурвалж үгүй болсон түүхийг хожуу тайлбарлая. Тэгэхээр Исмаилийн үндсэн сурвалжууд байдаггүй юм бол тэдний тухай бусдаас илүү мэдээлэл үлдээсэн 13-р зууны Иран болон Арабын түүхчдийн бүтээлээс тоймлон үзэхэд Хүлэгү хааны байлдан дагуулал Дундад Дорнодод эхлээгүй байхад Монголын Их хаад Исмаилийнхантай холбоотой байсан байна. Исмаилийн төлөөлөгч болох Имам гуравдугаар Жалал ал-Дин Хассан /Jalāl al-Dīn Ḥasan/ (1210-21) Чингис хаантай 1219 онд уулзсан тухай Ираны түүхч Жувайни бичсэн байдаг.<sup>4</sup> Үнэхээр Чингис хаан 1219-1225 он хүртэл Сартуул буюу Трансоксианы зүгт Хорезм болон Хорасаны нутгийнхныг айлгаж явсан тухай Монголын Нууц Товчоонд гардаг.<sup>5</sup> Эзэн Чингис хааны тухай болон Монголын тал нутагт хүчирхэж байгаа Монгол гүрний тухай Исмаилийн тагнуулынхан сайн мэдэж байсны улмаас Жалал ал-Дин Хассан Чингис хааныг олж уулзсан байж таарлаа. Уулзалт хоёр талдаа амжилттай болсон, учир нь Зэв Сүбээдэй нарын 1220-21 онд Хорасан болон Ираны нутгаар хийсэн анхны дайралтад Исмаилийн голлон сууршиж байсан Кухистан муж өртөөгүйгээр үл барам Монголчуудаас дайжсан олон ард Кухистанд орогнол олсон байна. Эдгээр хүмүүсийн нэг нь алдарт философич, Хүлэгү хааны одон орны судлалын төвийг байгуулсан Насир ал-Дин ал-Туси /Naṣīr al-Dīn Ṭūsī/ (1201-74) байсан байна. Өөр нэг онцлох зүйл бол Хорезмын Шагийн<sup>6</sup> эсрэг Монголчуудын довтолгооны тагнуулын албыг Исмаилийнхан залгаж байсныг Арабын сурвалж дурдсан байдаг.<sup>7</sup>

<sup>4</sup> Juvaynī, 'Alā' al-Dīn, *Ta'rikh-i Jahān-Gushā*, 1962, 248.

<sup>5</sup> Монголын Нууц Товчоо, 2004, §257-260.

<sup>6</sup> Хорезмийн Шаг 1220 онд Каспийн тэнгисийн нэгэн арал дээр нас барсан. Түүний хүү Жалал ал-Дин 1231 онд Курдуудын гарт үрэгдсэн.

<sup>7</sup> Ibn al-Athīr, *Tā'rikh al-Kamīl*, 1940; May, 2004, 239.

Монголчуудын Дундад Дорнодод 1230-40 онд хийсэн хоёрдугаар аян дайны үеээр Чормахан хорчи Кухистан хийгээд Аламутын нутгийг тойроод гарчээ. Энэ бол Чингис хаантай байгуулсан Исмаилийнханы гэрээ хүчин төгөлдөр байсныг гэрчилж байна. 1246 онд Исмаилийн тэргүүн Ала ал-Дин Мухаммад /'Alā al-Dīn Muḥammad/ (1221-55)/ хоёр элчээ (*dā'īs*) Гүюгийг (1246-48) хаан ширээнээ залрах ёслолд илгээжээ.<sup>8</sup> Тэрхүү ёслолд Орос (Суздаль), Хятад (Cathay), Солонгос (Корё), Трансоксиан, Хорасан, Ирак, Лур (Афганистан), Иран (Азербайжан), Ширван, Рум, Гүрж, Армяны ноёд, ван гүнтэн хийгээд Ром, Аллеро, Мосул, Багдадын элчээс гадна Аламутын буюу Исмаилийнханы элч оролцсон тухай Карпини номдоо дурдсан байдаг.<sup>9</sup> Энд нэг тодруулга хэлэхэд Ойрх болон Дундад Дорнодын дундад зууны түүхийг Монголоос өмнөх, Монголын, Монголоос хойш үе гэж хуваан хэвшсэн байдаг бол Исмаилийнханы түүхэнд Монголын үеийг Аламутын үе гэж нэрлэдэг байна.

Исмаилийнханы тухай өөр нэг мэдээг Рашид ал-Дин үлдээсэн байна. Тэр бээр Аламутын элч нарын авчирсан захидалд Гүюг хаан хилэгнэж маш хатуу үгтэй хариу илгээв гэж бичжээ.<sup>10</sup> Энэ чухамхүү ямар улбаатай байв гэдэг нь тодорхой бус боловч тун их чухал мэдээ байсан байж таарав. Гүюг хаан Элжигидэй<sup>11</sup> жанжныг тун яаравчлан Ираны нутаг руу илгээж тэнд суурин буй Монгол цэргийн дээд командлалыг гартаа авч Мусалманчуудын цайз хороодыг Исмаилийнхаас эхлэн устгах даалгавар өгчээ. Гүюг өөрөө хойноос нь мордох төлөвтэй байвч удалгүй таалал төгссөн байна.

Гүюг хааны дараа Мөнх хаанд (1251-59) Иран, Кавказ, Анатолийг захиран сууж байсан Монгол жанжин, Бэсүүд аймгийн уугуул Байжуу<sup>12</sup> Багдадын Калифын тухай гомдол гаргаж байхдаа Исмаилийнхан аюултай болж байгааг танилцуулж байжээ.<sup>13</sup> Үүний баталгаа Армян сурвалжид бас байна: Армяны нутагт захирагч байсан Цагаадай хэмээх Монгол жанжныг Исмаилийнхан алсан тухай тодорхой дурдсан байдаг.<sup>14</sup> Монгол Исмаилийнханы харилцаа биш болсныг ашиглан Сунни эрдэмтэд ('*ulama*') Дундад Дорнодод Исмаилийнханы улс төрийн ажиллагааны талаар Монгол хаанд гомдол мэдүүлж эхэлжээ.<sup>15</sup> Түүнээс гадна Исмаилийнхан өөрсдөө байдал эгзэгтэй болж байгаагай холбогдуулан Монгол хаадын Ордонд нууцаар байн байн үзэгдэх болсон байна. Ромын Пап ламын илгээсэн элч нарын нэг Карпини Мөнх хааныг алахаар завдаж буй янз бүрээр зүсээ хувиргасан 40 ассассин хааны ордонд харагдсан тухай өгүүлсэн байдаг.<sup>16</sup> (Латинаас орчуулсан зарим хувилбарт 400 гэсэн тоо байдаг).

Монгол Исмаилийн харилцаа яагаад муудав гэсэнд тодорхой хариу баримт байхгүй ч ямар ч байсан муудсан нь илт болов. Миний хувийн бодлоор асуудлын гол эдийн засаг талдаа

<sup>8</sup> Juvaynī, 1962, 205; Дафтари, 1998, 150.

<sup>9</sup> Komroff, Manuel, ed. *Contemporaries of Marco Polo*, 1928, 41.

<sup>10</sup> Rashīd al-Dīn, 1996, 50.

<sup>11</sup> Францын Луи хаан 1248 онд илгээсэн, Загалмайтаны ариун дайныг Монголын байлдан дагуулалтай хавсрах Монголчуудын санааг илэрхийлсэн захидлын эзэн; Jackson, *The Mongols and the West*, 2005, 98-99.

<sup>12</sup> 1243 онд Селжүк Султаныг Көсө Дагийн тулаанд ялж эрхэндээ оруулсан ба Бага Азийн захирагч байсан. Султаны арми 16 түмэн, монголын арми 3 түмэн байсан гэсэн мэдээ байна; Het'um, 1842, 38.

<sup>13</sup> Rashīd al-Dīn, 1954, 684.

<sup>14</sup> Kirakos Gandzakets'i, *Patmut' iwn Hayots'*, 1961, 264, 275.

<sup>15</sup> Jamal, 2002, 46.

<sup>16</sup> Komroff, ed. *Contemporaries of Marco Polo*, 1989, 168.

байсан байх. Армян сурвалжийн мэдээгээр Исмаилийнхан гэнэтийн татвар хураадгаараа ард олныг зовоож байсан гэдэг. Татвараа төлөөгүй нэгнийг аймшиггүйгээр алж талдаг байжээ. Ганзакийн Киракос хэмээх Армян түүхч:

*Орган нэртэй нэгэн харамч ноён байсан хийгээд тэр Исмаилийнханы гарт хөөрхийлөлтэй үрэгдэж билээ. Тэрээр хотын гудмаар алхалж байхад хэсэг хүмүүс гудмын нөгөө талаас түүн рүү ойртон нэгэн бичиг гартаа барин шударга ёс, шударга ёс хэмээн хашигчив. Орган учрыг асууж зогстол нөгөө хүмүүс тал талаас түүн рүү үсэрч ирэн хутга, мээ гарган хөөрхий Органы амийг хороов*

гэж бичжээ.<sup>17</sup>

Хутгалах нь Исмаилийнханы аллага хийх гол арга байсан болохыг судлаачид тогтоосон билээ. Энэ тухай бид эргэн ярилцах болно.

Улс төрийн хувьд байдал ийм байхад шашин шүтлэгийн хувьд Исмаилийнхан өөрсдийн үзэл бодлоосоо болж олон дайсантай байсан байна. 13-р зууны Исмаилийнханы гол нутаг Ираны хойд нутгаар байжээ. Аламут бол Ираны Казвин мужид байдаг. Тэр үеийн Казвинчууд Сунни мусальманчууд байсан байна. Иймд бөөрөнд нь байгаа буруу номтныг дарах ариун дайнд тэд зэхэж байжээ. Казвины шашны хуульч (Qāzī) Шамс ал-Дин/ Shams al-Dīn Qazvīnī/, Гүюг хааны хаан ширээнд залрах ёслолд оролцоноосоо хойш хэд хэдэн удаа Монгол руу аян замын жолоогоо залах болсны гол шалтгаан бол Исмаилийнханы эсрэг тэмцэлдээ Монголчуудын туслалцааг авахад оршиж байжээ. Ираны 13-р зууны түүхч Жүзжаны мэдээлснээр энэхүү Казвины Шамс ал-Дин Мөнх хаанд Исмаилийнханы бүгж буй уул хадан цайз хийгээд Исмаилийн улс төрийн хорт ажиллагаанаас болгоомжлох талаар сануулан сүртэйгээр тайлбарлаж байжээ.<sup>18</sup> Казвин мужийнхан Исмаилийнханыг Мусульман биш гэж үзээд хэдийнээ тэдэнтэй тулалдаж байсан түүхтэй юм байна. Чингис хаанд 1219 онд бараалхаж байсан дээр дурдсан (Нео-Муслим хочит) Жалал ал-Дин Хассан Исламын “үнэн алдартан” болохоо харуулах ба буруу номын үзлээсээ татгалзсаныг Казвинчуудад батлахын тулд Багдад орж Сунни болж “уулын өвгөн” Хасан Саббах хийгээд түүний залгамжлагчдын үүсгэн байгуулсан Аламутын алдарт номын санг Казвинчуудын нүдэн дээр галдан шатаасан тухай Жувайни бичсэн байдаг.<sup>19</sup> Энэ хэрэг Монголын байлдан дагууллаас өмнө болсон хэдий ч Исмаилийн оюун санааны өв хөрөнгө болох номын сангийн устгал Монголчуудад тохоогдсоор л байгаа. Монголчуудын гарт тэрхүү номын сангийн үлдэгдэл үрэгдсэн гэж үзвэл илүү ортой байх сан.

Монгол-Исмаилийн харилцаанд холбоотой өөр нэгэн мэдээ байдаг. Ираны түүхч Мустафи Казвини *Zafar-Nāma* түүхэн сурвалждаа Хүлэгү-г Иран руу дайлаар мордуулах санааг мөнөөх элч Шамс ал-Дин Мөнх хаанд анх хэлсэн мэрээр бас бичсэн байдаг.<sup>20</sup> Энэ мэдээ хэр ортойг хэлэхэд бэрх боловч ямар ч байсан Мөнх хаан тэртээ дөчөөд жилийн өмнө Эзэн Чингис хаан Ираны хавь нутгийг байлдан дагуулсан атлаа өнөөг хүртэл тэр иргэдийг Боржигин овогтон захирч байгаагүйг тооцоолон бодож өөрийн дүү Хүлэгү-г 1253 оны үхэр жил мордуулж

<sup>17</sup> Kirakos Gandzakets'i, 1961, 226-28.

<sup>18</sup> Jūzjānī, *Tabakāt-i-Nāsīrī*, 1970, 1192-96.

<sup>19</sup> Juvaynī, 1962, 244.

<sup>20</sup> Lane, George. *Early Mongol Rule in Thirteenth Century Iran; a Persian Renaissance*, 2003, 16.

Иран, Рум, Кавказ, Сирийг бүрэн эзэлж цэрэг хийгээд захиргааны үйл ажиллагааг хянах үүрэг өгчээ.<sup>21</sup> Хүлэгү 1256 он хүртэл Бат хааны аяыг даган Окс буюу Аму Дарья мөрний наад эрэг дээр саатсаар зөвхөн 1255 онд Бат хаан таалал төгссөний дараа буюу 1256 оны эхээр Иранд хүрэлцэн иржээ.<sup>22</sup> Энэ нэг жишээгээр Чингис хааны үр сад ахын ёсыг ихэд дээдэлж, хэдий Тулуй хааны хөвүүн Их хаанд өргөмжлөгдсөн байсан ч Зүчийн удмын үг илүү нөлөөтэй байсныг гэрчилж байна. Хүлэгү хаан Алтан Ордны нутагт саатаж байхдаа өөрийн өрлөг жанжин Хэт-Бухыг<sup>23</sup> 1253 онд Иран руу илгээж Исмаилийнханы хадан цайзыг буулгаж байх үүрэг өгчээ. Судалгаагаар Исмаилийнханы цайзын тоо 70 гаруй байсан гэж үздэг, зөвхөн Кухистан болон Казвин мужуудад 35 нь байсан байна. Эдгээрийн дунд Гирд-Кух цайз хамгаалалтаа бэхлэн тэмцээр 30 жилийн дараа Ил хаан Авагт бууж өгсөн байна. Бусад цайз нь Палестин, Сирийн эрэг хавийн нутгаар тархсан байжээ.

Товчлон хэлэхэд Хүлэгү хаан Хэт-Бух, Хөх-Илгэ болон бусад жанжны хамт Исмаилийнханы цайзыг нэг нэгээр буулгасаар тэдний тэргүүн Имам Рукн ал-Дин Хур-Шагийн бүгж байсан Маймун-Диз /ендрөөрөө 600 м, уртаашаа 450 м, өргөөшөө 90 м/ хадан цайзын бэлд 1256 оны 11-р сарын эхээр ирж уулыг бүслэн авчээ. 4 хоногийн дараа Рукн ал-Дин бууж ирэхээ мэдэгдэн элч илгээж. Элч Имамын хүсэлтийг дамжуулж амь насны баталгааг даасан зарлиг Хүлэгү хаанаар гаргуулжээ. Эхлээд Рукн ал-Дин хүүгээ хэдэн сайдтай илгээж, Хүлэгү хаан хүүг нь жинхэнэ хүү биш болохыг мэдээд хүүг буцаажээ. Рукн ал-Дин дараагаар ах дүүсээ нэг нэгээр илгээжээ. Хүлэгү хаан хариуд нь танай гэр бүлийг бид хамгаалж байна, тэргүүн та өөрөө уулнаасаа бууж ирнэ үү хэмээн 9 удаа элч илгээж тэвчээртэй хүлээн сууж байж. Рукн ал-Дин өвлийг хүртэл эрга чаргаар монголчуудыг саатуулбал Армянаас татаж байсан хоол хүнсний зам өртөө гаршгүй болж монголчуудын морьд тэжээлгүй болох найдлагаар цаг хожихоор тооцоолж байв. Үүнийг мэдсэн Хүлэгү тэр хооронд Хэт-Бух болон бусад жанжнаа хажуугийн бага хамгаалалттай цайзыг буулгахаар явуулсаар байв. Олон цайз хүчтэй эсэргүүцэл (хэт даврагч *fidā'is*-ын эсэргүүцэл) үзүүлж байсны нэг жишээ болох Ламасар цайзын хамгаалагчид бүтэн нэг жил тэмцэж байж буусан байна. Хариу элч илгээх болгондоо Хүлэгү хаан Рукн ал-Динд бүх цайз хамгаалалтаа Монголчуудад бууж өгөх шаардлага тавь гэж дамжуулсаар байж, Рукн ал-Дин ч бага ач холбогдол бүхий цайзаа нэрлээд явуулаад байж. Ингэж олон удаагийн дипломат харилцааны үр дүнд 11-р сарын эцсээр Исмаилийнханы тэргүүн Монголчуудад дагаар орохоор Маймун-Дизээс бууж иржээ.<sup>24</sup> Хүлэгү хаан Рукн ал-Динийг анх хараад "нялх тэнэг зөлиг шив дээ" гэж гайхсан гэдэг. Хүлэгү түүнийг найрсгаар хүлээн авч өөрийн орд байрлах Хамадан руу авчирж тэнд хяналтдаа саатуулж байхад Рукн ал-Дин монгол бүсгүйд дурлаж түүнтэй гэр бүл болон Монгол Их хааны хүргэний тоог нэгээр нэмжээ.<sup>25</sup>

13-р зуунд дагаар орсон иргэд, улсын тэргүүнийг Монгол руу илгээж Их хаад тэдний эрхийг дархалж алба барих буюу албаас чөлөөлөх зарлиг гаргаж пайз болон гэрэгийн өргөмжлөл соёрхдог байжээ. Үүний жишгээр Хүлэгү Рукн ал-Дин Хур Шагийг 1257 оны 3-р сард Монгол руу өртөөлөн явуулжээ.

<sup>21</sup> Rashīd al-Dīn, 1954, 685.

<sup>22</sup> Трепавлов В., *Государственный строй Монгольской Империи XIII в.*, 1993, 81.

<sup>23</sup> Найман аймгийн хүн, буурчийн зэрэгтэй байсан, Багдад, Алеппо, Дамаскийг байлдан дагуулсан, 1261 онд Аян Жанутат Мамлюкуудад алуулсан,

<sup>24</sup> Juvaynī, 1962, 133.

<sup>25</sup> Rashīd al-Dīn, 1946, 31.

Үүнээс хойш тохиосон түүхэн үйл явдал миний гайхширлыг төрүүлээд байгаа юм. Рашид ал-Дины бичсэнээр бол Мөнх хаан Исмаилийн Имам Монгол руу ойртон ирж буй мэдээг дуулаад өртөө улааг зовоож тэрийг нааш нь ирүүлж яах вэ, замд нь хороо гэсэн үүрэг өгчээ.<sup>26</sup> Исмаилийн 70 гаруй цайзын тал хагасаас илүү нь Сири Палестины нутгаар байсан тухайг эргэн санаад, бас тэдний тэргүүнийг дагаар оруулсны дараа Сунни Багдадын эсрэг Хүлэгү хааны аян дайнд Исмаилийнханыг ашиглах бололцоог бодоод, мөн дайсандаа охин өгч хүргэн болгож худ ургийн харилцаагаар улс гүрнийг төвхнүүлж байсан Чингис хааныхаа мэргэн ухааныг эргэцүүлэн бодоод ч Мөнх хаан ийм томоогүй зарлиг гаргасанд итгэж боломгүй байгаа юм.

Исмаилийн түүхийг илүү нягталж бичсэн Жувайнийн өчсөнөөр бол Мөнх хаан Исмаилийн Имамыг Хар-Хоринд найрсгаар хүлээн авсан боловч Ламасар, Гирд-Кух цайз одоо хүртэл бууж өгөөгүйг сануулан зэмлээд нутагт нь буцааж цайзаа буулгаж өг гэсэн зарлигтай замд нь гаргаад Монголын Тиаб/Ti'āb (پاعیت) хэмээх газар хороосон гэжээ.<sup>27</sup> Энэ мэдээ бас эргэлзээтэй санагдаад байгаа юм. Учир нь нэгдүгээрт, олон хүчтэй цайзыг буулгах үүрэг өгөөд явуулсан хүнээ яагаад замд нь алах болов? Хоёрдугаарт, Тиаб хэмээх газар маань чухам хаана байна вэ? Нэрт эрдэмтэн Бойл Жувайнийн *Ертөнцийг Байлдан Дагуулагч* номыг англи хэлнээ орчуулахдаа Тиаб нь Монголын Хангай нуруу юм гэсэн бол, Францын эрдэмтэн Д'оссон (d'Ohsson) Тунгат гэж орчуулаад тэр нь Тагна уул юм гэж бичжээ.<sup>28</sup> Дундад зууны харийн орны элч төлөөлөгчийн аялж байсан маршрутыг судалбал бүгд Хар Хорин хүртэл Уйгарын нутгаар дайрч байсан байна, үүнийг баримталбал Алтай, Хангай нуруудын урдуур тойрч гарсан зам болох таамагтай тул Тиаб гэдэг маань чухам Монголд юм уу гэдгийг тодруулах шаардлагатай юм.

Гуравдугаарт, Жувайний мэдээгээр дагалдан явсан бараа бологчид нь Рукн ал-Диныг хороов гэдгээс улбаалан дагалдан явсан Монгол улаачдыг хэлж байна уу, Исмаилийнханыг хэлж байна уу, хэнийг хэлж байна вэ гэсэн асуулт бас тайлагдаагүй үлдэж байна.

Ямартаа ч Шиа Исмаилийн тэргүүнийг хороогдсон байдлаар түүхэн сурвалжуудад үлдээх сонирхол Сунни Исламын түүхчдэд байсан. Тэд Шиа Исмаилийнханыгаа таашаан магтан бичихгүй нь лавтай гэдэгтэй адил Монголчуудын хараат байсан хүмүүс яагаад ч зөвтгөхгүй нь мэдээж. Иймд Исмаилийн түүхнээ хамгийн муу нэрээр үлдсэн Монголчууд Исмаилийн сүүлийн Имамыг нутагтаа урин хороогоод түүний үр удмыг хүйс тэмтэрч, басхүү тэдний өвлөж ирсэн ном судрыг галдан шатаасан гэдэг мэдээ хэдийгээр тархсан боловч эргэлзээтэй зүйл их байгаа юм. Өнөө Франц хийгээд Энэтхэгт аж төрж байгаа Исмаилийн Ага Хан бол Низари Исмаилийн сүүлийн Имамын үр удам гэдгийг эрдэмтэн Дафтари нотолсон байгаа.

Та бүхэнд сонордуулсан энэхүү сэдвийг Армян-Исмаилийн харилцааны талаас авч судлан 2006 оны 11-р сард Лондон дахь Исмаилийн Судлалын Төвд хэлэлцүүлж эрдэмтэн мэргэдээс санал авахад цочирдмоор нэгэн мэдээлэл надад ирсэн юм. Энэ нь 2007 онд Техран хотноо хэвлэгдэн гарах байсан *Диван Гадимиат* (تایم داق نوید) хэмээх нэгэн номд Эзэн Чингис хааныг маань Исмаилийнхан боомилон хороосон тухай найраглал бий гэнэ ээ. Хэдийгээр

<sup>26</sup> Rashīd al-Dīn, 1954, 31.

<sup>27</sup> Juvaynī, 1962, 277.

<sup>28</sup> Boyle, *The Mongol World Empire*, 1997, 609 (n. 9).

зохиолтой нь танилцаагүй ч үүнийг няцаах нэгэн хариулт байгаа юм. Ассассинууд хүн алахдаа хутга дүрж алдаг заншилтай байж, энэ бол тэдний мэргэшсэн арга барил, харин эзэн хааныг маань яагаад гараараа, бас боож алах болсон юм бэ?

Хэдийгээр түүхийн шинжлэх ухаанд олон янзын магадлал гарахыг үгүйсгэдэггүй боловч бидний Монголчуудын түүхийг дуртай нэгэн нь гуйвуулах аливаа хандлагад няцаалт өгч, бахархах зүйлээрээ бахархаж сургамж авахаас нь авч, хайрлан хандаж баймаар байна аа.

Иймээс бидний монголчууд өөрсдийн түүхийн судалгааг өөрсдөө хийж түүхийн үнэн зөвийг чадах ядахаараа өөрсдөө гаргаж ирэх цаг болжээ гэж хэлмээр байна. Сурвалжуудыг эзлэгдэж байсан, дагаар орсон иргэд бичиж үлдээснийг санаж байх хэрэгтэй, яагаад гэвэл тэдний үлдээсэн өв дээр орчин цагийн судалгааны ном зохиолууд бичигдсээр байх болно шүү дээ.



## НОМ ЗҮЙ

- Anonymous (MNT), *The Secret History of the Mongols*, trans. I. De Rachewiltz, 2 vols. Leiden: Brill, 2004.
- , *Монголын Нууц Товчоо*, сонгодог эх, ed. D. Tserensodnom et al, Улаанбаатар: Мөнхийн Үсэг, 2004.
- , *Монголын Нууц Товчоо*, (edition on Historical Military Terms and Terminologies) Улаанбаатар: Хар Сүлд, 2004.
- , *Монголын Нууц Товчоо*, Улаанбаатар: Болор Судар, 2003.
- , (SHM) *The Secret History of the Mongols: The Life and Times of Chinggis Khan*, trans. Onon Urgunge. Richmond: Curzon, 2001.
- Ibn al-Athīr (1160–1233), *Al-Kāmil fi'l-ta'rikh*, trans. P. Juze, Baku: Azerbaijan Institute of History, 1940.
- Juvaynī, 'Alā' al-Dīn (623/1225–681/1283), *Tasliyat al-Ikhvān*, ed. 'Abbās Māhyār. Tehran: Ābād, 1982.
- , *Ta'rikh-i Jahān-Gushā*, ed. Mīrzā Muhammad Qazvīnī, 3 vols, Tehran: Pīk Irān, 1962.
- , *The History of the World Conqueror*, trans. J. A. Boyle. Manchester: Manchester University Press, 1997.
- Jūzjānī, Minhāj b. Sirāj M. (589/1193– d. after 664/1265), *Tabakāt-i Nāsīrī* [written in 657/1259–658/1260], trans. H. G. Raverty, ed. W. N. Lees, 2 vols, Reprint New Delhi: Oriental Books, 1970.
- Kirakos Gandzakets'i (1200–1271), *Patmut' iwn Hayots'*, ed. Melik'-Ohanjanyan. Erevan: Academy of Sciences Press, 1961.
- Komroff, Manuel, ed. *Contemporaries of Marco Polo: Consisting of the Travel Records to the Eastern Parts of the World of William of Rubruck [1253–1255]; the Journey of John of Pian de Carpini [1245–1247]; the Journal of Friar Odoric [1318–30] and the Oriental Travels of Rabbi Benjamin of Tudela [1160–1173]*, New York: Dorset Press, 1989.
- Rashīd al-Dīn, Faḍl Allāh (ca 645/1247–718/1318), *Compendium of Chronicles: A History of the Mongols*. trans. W. M. Thackston, Harvard University Press, vol. 1, 1998; vol. 2, 3, 1999.
- , *Jāmi' al-Tavārikh* (704/1306–710/1311), ed. B. Karīmī, Tehran: Āqbāl, 1954.
- , *Sbornik Letopisei* (Jāmi' al-Tavārikh), trans. L. A. Khetagurov, vol. 1, part 1; trans. O. I. Smirnova, vol. 1, part 2, ed. A. A. Semyonov, Moscow, Leningrad: Academy of Sciences Press, 1952; trans. Y. P. Verkhovskiy, ed. I. P. Petrushevskii, vol 2, Moscow, Leningrad: Academy of Sciences Press, 1960; trans. A. K. Arends, ed. A. A. Romaskevich, vol 3, Moscow, Leningrad: Academy of Sciences Press, 1946.
- Boyle, John Andrew, *The Mongol World Empire, 1206–1370*, London: Variorum Reprints, 1977, 554–63.
- , "Rashīd al-Dīn: The First World Historian" in: *Iran*, 9, (1971): 19–26.
- , ed. *The Cambridge History of Iran. The Saljuq and Mongol Periods*, 8 vols, vol. 5, Cambridge: Cambridge University Press, 1968.
- Jamal, Nadia, *Surviving the Mongols*. London: I. B. Tauris, 2002.
- Jackson, Peter, *The Mongols and the West. 1221–1410*, London: Pearson /Longman, 2005.
- Lane, George, *Early Mongol Rule in Thirteenth Century Iran; a Persian Renaissance*, 2003.

Melville, Charles, "Doquz Khatun." *Encyclopaedia Iranica* VII (1996): 475-76.

Spuler, Barthold, *History of the Mongols: Based on Eastern and Western Accounts of the Thirteenth and Fourteenth Centuries*, New York: Dorset Press, 1972.

Трепавлов В., *Государственный строй Монгольской Империи XIII в.*, 1993.554–63.

—, "Rashīd al-Dīn: The First World Historian" in: *Iran*, 9, (1971): 19–26.

—, ed. *The Cambridge History of Iran. The Saljuq and Mongol Periods*, 8 vols. vol. 5, Cambridge: Cambridge University Press, 1968.

Jamal, Nadia, *Surviving the Mongols*. London: I. B. Tauris, 2002.

Jackson, Peter, *The Mongols and the West, 1221–1410*, London: Pearson /Longman, 2005.

Lane, George, *Early Mongol Rule in Thirteenth Century Iran; a Persian Renaissance*, 2003.

Melville, Charles, "Doquz Khatun." *Encyclopaedia Iranica* VII (1996): 475-76.

Spuler, Barthold, *History of the Mongols: Based on Eastern and Western Accounts of the Thirteenth and Fourteenth Centuries*, New York: Dorset Press, 1972.

Трепавлов В., *Государственный строй Монгольской Империи XIII в.*, 1993.